



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 391

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр зарласан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Дарханбаатар, мэргэжилтэн Т.Хулан нарыг томилсугай.

2.Төрийн өмчийн төлөөлөгчийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч В.Дарханбаатар, Т.Хулан нарт даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН


ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Г.Тогтолцогт Нийн Баруунтэвэр Улаанбаатар

0002213

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дүгээр сарын ...¹⁹-ны өдрийн
...³⁹¹ дугаар тогтоолын хавсралт



**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД
ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон дараах удирдамжийг баримтална:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн А-1/3555 дугаар албан бичгээр “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанид хүргүүлсэн компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөлд өгсөн саналыг чиглэл болгон тус компанийн дүрмийг батлахад санал өгч оролцох;

2. Засгийн газрын 2018 оны “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай 245 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг төлөөлж Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, “Эрдэнэс таван толгой” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарыг сонгож томилох, хараат бус гишүүдийг Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулахад санал өгч оролцох.

-----оо-----